

Нэгдүгээр бүлэг

Бичсэн Administrator

2010 оны 2-р сарын 05, Баасан гариг, 02:39 -

Нэгдүгээр зүйл

1. Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс мон.
2. Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь торийн үйл ажиллагааны үндсэн зарчим мон.

Хоёрдугаар зүйл

1. Монгол Улс торийн байгууламжийн хувьд нэгдмэл байна.
2. Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхон засаг захиргааны нэгжид хуваагдана.

Гуравдугаар зүйл

1. Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн торийн үйл хэрэгт шууд оролцож, мон сонгож байгуулсан торийн эрх барих толоологчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.
2. Торийн эрх мэдлийг хууль бусаар авах, авахаар завдахыг хориглоно.

Дөрөвдүгээр зүйл

1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна.
2. Монгол Улсын хилийг хуулиар бататгана.
3. Хууль гаргахгүйгээр гадаадын цэргийн хүчнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлуулах, дамжин онгорүүлэхээр улсын хил нэвтрүүлэхийг хориглоно.

Тавдугаар зүйл

1. Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, оорийн орны өвөрмоц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна.
2. Тор нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлогчийн эрхийг хуулиар хамгаална.
3. Өмчлогчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.
4. Тор нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.
5. Мал сүрэг бол үндэсний баялаг мон богоод торийн хамгаалалтад байна.

Зургадугаар зүйл

1. Монгол Улсад газар, түвний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, торийн хамгаалалтад байна.
2. Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түвнчлэн газрын хэвлий, түвний баялаг, ой, усны нооц, ан амьтан торийн өмч мон.
3. Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхон Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно. Энэ нь газрын хэвлийг өмчлоход хамаарахгүй. Иргэд хувийн өмчийнхоо газрыг худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлолд шилжүүлэх, түвнчлэн торийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглоно.
4. Тор газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн нохох олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн амын

Нэгдүгээр бүлэг

Бичсэн Administrator

2010 оны 2-р сарын 05, Баасан гариг, 02:39 -

эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно.

5. Тороос гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хvнд газрыг толбор, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол, журмаар ашиглуулж болно.

Долдугаар зvйл

1. Монголын ард түмний тvvх, соёлын дурсгалт зvйл, шинжлэх ухаан, оюуны ов торийн хамгаалалтад байна.

2. Иргэний туурвисан оюуны үнэт зvйл бол зохиогчийнх нь өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн.

Наймдугаар зvйл

1. Монгол хэл бол торийн албан ёсны хэл мөн.

2. Энэ зvйлийн 1 дэх хэсгийн заалт нь хvн амын оор хэл бvхий үндэстний цоонх эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны вйл ажиллагаа явуулах эрхийг вл хондоно.

Есдүгээр зvйл

1. Монгол Улсад тор нь шашнаа хvндэтгэж, шашин нь тороо дээдэлнэ.

2. Торийн байгууллага шашны, сvм хийд улс торийн вйл ажиллагаа эрхлэн явуулж болохгvй.

3. Тор, сvм хийдийн хоорондын харилцааг хуулиар зохицуулна.

Аравдугаар зvйл

1. Монгол Улс олон улсын эрх зvйн нийтээр хvлээн зовшоорсон хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна.

2. Монгол Улс олон улсын гэрээгээр хvлээсэн vүргээ шударгаар сахин биелvүлнэ.

3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хvчин тоголдор болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил вйлчилнэ.

4. Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мордохгvй.

Арван нэгдүгээр зvйл

1. Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь торийн vүрэг мөн.

2. Монгол Улс оорийгоо хамгаалах зэвсэгт хvчинтэй байна. Зэвсэгт хvчний бvтэц, зохион байгуулалт, тvvнд алба хаах журмыг хуулиар тогтооно.

Арван хоёрдугаар зvйл

1. Монгол Улсын тусгаар тогтнол, бvрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг нь Торийн сvлд, туг, далбаа, тамга, дуулал мөн.

2. Торийн сvлд, туг, далбаа, дуулал нь Монголын ард түмний тvvхэн уламжлал, хvсэл тэмvүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ.

3. Торийн сvлд нь ариун цагаан онгийн бадам цэцэг суурьтай, тогсголгvй vргэлжлэн дэлгэрэх түмэн насан хээгээр ховоолсон, монх тэнгэрийг бэлгэдсэн дугариг хох дэвсгэртэй байна. Сvлдний тов хэсэгт Монгол Улсын тусгаар тогтнол, бvрэн эрхт байдал,

Нэгдүгээр бүлэг

Бичсэн Administrator

2010 оны 2-р сарын 05, Баасан гариг, 02:39 -

цог хийморийг илтгэсэн алтан соёмбо, эрдэнийн хвлгийг хослуулан дүрсэлсэн байна. Сүлдний хүрээний магнайн хэсэгт эрт, эдүгээ, ирээдүй гурван цагийг бэлгэдсэн хвслийг хангагч чандмань эрдэнэ, доод хэсэгт эх газрыг толоолсон ногоон онгийн уулан хээ, ашид дэвжихийн олзий хутаг оршсон хүрдийг тус тус дүрсэлнэ. Хүрдийг хадгаар дээдлэн сүлжсэн байна.

4. Монголын нэгдсэн тулгар торийн уламжлалт Их цагаан туг нь Монгол Улсын торийн хүндэтгэлийн бэлгэдэл мон.

5. Монгол Улсын торийн далбаа нь улаан, хох, улаан хосолсон онготэй байна. Далбааны гурав хуваасны нэгийн хэмжээтэй дундахь хэсэг нь монх тэнгэрийн хох, түүний хоёр тал нь мандан бадрахын бэлгэдэл улаан онготэй байна. Далбааны ишин талын улаан дэвсгэрийн тов хэсэгт алтан соёмбо байрлуулна. Далбааны оргон, урт нь 1:2-ын харьцаатай байна.

6. Торийн тамга дорволжин хэлбэртэй, голдоо торийн сүлдтэй, сүлдний хоёр талаар Монгол Улс гэсэн бичээстэй, арслангийн дүрс бүхий бариултай байна. Торийн тамгыг Монгол Улсын Ерөнхийлогч барина.

7. Торийн бэлгэ тэмдгийг дээдлэн хэрэглэх журам, торийн дууллын үг, аяыг хуулиар бататгана.

Арван гуравдугаар зүйл

1. Монгол Улсын торийн дээд байгууллагууд байнга оршдог хотыг Улсын нийслэл гэнэ. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот мон.

2. Монгол Улсын нийслэлийн эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.